



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар
хот

Хөндлөнгийн хяналт тавих тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын эзэлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах үүрэг бүхий хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог зохих журмын дагуу хянаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
Эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ